



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

“Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл,
технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт
үйлдвэрийн газар байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Хан-Уул дүүргийн шинэ суурьшлын бүсэд Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2.“Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц орон тоог баталж, санхүүжилтийн болон бусад шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТТУЛГА

1110100491